



ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН



УЛСЫН
АВАРГА
2024

НАСАНД ХҮРЭГЧ МАСТЕР



2024.12.21-22

БАЯНГОЛ СПОРТЫН ХОРОО

УДИРДАМЖ

ОЛИМПЫН ТАЕКВОНДОГИЙН НАСАНД ХҮРЭГЧ, МАСТЕР, ПАРАТАЕКВОНДОГИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН 2024

1. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ: МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО

ХАЯГ:	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон
УТАС:	(976) 7015-5500
ИМЭЙЛ:	mongoliatekwondo@gmail.com
ВЭБ:	www.mongol-taekwondo.com

2. ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО:

ХАЯГ:	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Спортын төв ордон
УТАС:	(976) 8619-0073
СОШИАЛ:	https://www.facebook.com/БичигХэрэг
ВЭБ:	https://www.facebook.com/MongolTaekwondo

3. БАЙРШИЛ: Баянгол дүүргийн спортын хорооны заал
Баянгол дүүрэг, 15-р хороо, Хасбаатарын гудамж

4. ОГНОО: 2024 оны 12 сарын 21, 22

5. ШААРДЛАГА:

Тэмцээнд оролцогч **Тамирчдад** Монголын таеквондогийн холбооны дүрэм, журмын дагуу дараах шаардлага тавигдана.

ШААРДЛАГА 1:	Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна. /жич: Тэмцээн бүсний ангилалгүй зохион байгуулагдана/
ШААРДЛАГА 2:	Тамирчин нь Монголын таеквондогийн холбооны цахим бүртгэлийн системд бүргүүлсэн байх шаардлагатай байх ба хүчинтэй лицензтэй байна.
ШААРДЛАГА 3:	Тамирчид шилбэ, шуу, шүд /өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэй/, эмзэг эрхтний хамгаалалт болон КрNr цахим мэдрэгчтэй оймсыг бэлдэж ирэх шаардлагатай.

Багт тавигдах шаардлага:

ШААРДЛАГА 1:	Тэмцээнд оролцох байгууллага нь монголын таеквондогийн холбооны албан ёсны гишүүн байгууллага байна.
ШААРДЛАГА 2:	Оролцогч байгууллага нь холбоонд татвар, хураамжийн үлдэгдэл тооцоогүй байх.

Дасгалжуулагч

ШААРДЛАГА 1:	Монголын таеквондогийн холбооны дасгалжуулагчийн В зэрэгтэй эсвэл олон улсын дасгалжуулагчийн эрх бүхий дасгалжуулагч тамирчдыг дэвжээнд авч гарах эрхтэй.
ШААРДЛАГА 2:	Хагас шигшээ болон шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас /костюм/ өмсөх шаардлагатай
ШААРДЛАГА 3:	Тэмцээнд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замд болон тэмцээний үеэр хариуцсан тамирчдынхаа аюулгүй байдалд хяналт тавих нь тухайн багийн дасгалжуулагчийн үүрэг.
ШААРДЛАГА 4:	Тэмцээний үеэр дасгалжуулагч нь ямар ч төрлийн малгай өмсөхийг хориглоно.

6. ЖИНГИЙН АНГИЛАЛ:

Насанд хүрэгч / 17+ нас /:

Эр		Эм	
- 54 кг	54 кг хүртэлх	- 46 кг	46 кг хүртэлх
- 58 кг	54 кг жингээс 58 кг жингийн хооронд	- 49 кг	46 кг жингээс 49 кг жингийн хооронд
- 63 кг	58 кг жингээс 63 кг жингийн хооронд	- 53 кг	49 кг жингээс 53 кг жингийн хооронд
- 68 кг	63 кг жингээс 68 кг жингийн хооронд	- 57 кг	53 кг жингээс 57 кг жингийн хооронд
- 74 кг	68 кг жингээс 74 кг жингийн хооронд	- 62 кг	57 кг жингээс 62 кг жингийн хооронд
- 80 кг	74 кг жингээс 80 кг жингийн хооронд	- 67 кг	62 кг жингээс 67 кг жингийн хооронд
- 87 кг	80 кг жингээс 87 кг жингийн хооронд	- 73 кг	67 кг жингээс 73 кг жингийн хооронд
+ 87 кг	87 кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 73 кг	73 кг жингээс дээш жинтэй тамирчид

Мастер /31 ба түүнээс дээш нас/:

Эр		Эм	
- 58кг	58кг хүртэлх	- 49кг	49кг хүртэлх
- 68кг	58кг жингээс 68кг жингийн хооронд	- 57кг	49кг жингээс 57кг жингийн хооронд
- 80кг	68кг жингээс 80кг жингийн хооронд	- 67кг	57кг жингээс 67кг жингийн хооронд
+ 80кг	80кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 67кг	67кг жингээс дээш жинтэй тамирчид

Паратаеквондо /17 ба түүнээс дээш нас/:

Эр		Эм	
- 63кг	63кг хүртэлх	- 52кг	52кг хүртэлх
+ 63кг	63кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 52кг	52кг жингээс дээш жинтэй тамирчид

Мастер ангилалд хамаарах тамирчин нь өөрийн хүсэлтээр насанд хүрэгчдийн ангилалд оролцох боломжтой.

7. ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ:

Тэмцээн Кр№р цахим онооны системээр явагдана.

7.1 Тэмцээнийг Дэлхийн таеквондогийн холбооны дүрмийн дагуу хасагдах системээр явуулна.

7.2 Хоёр үе ялсан тамирчин тэмцээнийг цааш үргэлжлүүлэх аргачлалаар явагдах ба нэгж үеийн үргэлжлэх хугацаа хоёр минут байх ба үе хоорондын завсарлага нэг минут байна.

8. БҮРТГЭЛ:

- I. Бүртгэлийг цахимаар хийх ба Монголын таеквондогийн холбооны албан ёсны бүртгэлийн систем болох www.mongol-taekwondo.com хаягаар бүртгүүлнэ.
- II. Бүртгэлийн системд тамирчид бүртгүүлэхдээ сүүлийн 6 сард авахуулсан цээж зургийг ашиглана.
- III. Оролцогчийн хураамжийг зөвхөн цахимаар шилжүүлнэ.

Оролцогчийн хураамж хүлээн авах данс:

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

9. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ, БҮРТГЭЛИЙН ХУГАЦАА:

- I. **Энгийн бүртгэл:** 2024 оны 11 сарын 25-ны өдрөөс 12 сарын 13-ны 23:59 цаг хүртэл
 - Тэмцээнд оролцогч тамирчны дэвжээний хураамж 50.000 төгрөг (тавин мянган) төгрөг
 - Мастер болон паратаеквондогийн ангилалд оролцох тамирчид хүчинтэй лицензтэй байхыг шаардахгүй.
- II. **Хоцорсон бүртгэл:** 12 сарын 13-ны 23:59 цагаас 12 сарын 16-ны 18:00 цаг хүртэлх бүртгэлд 20.000₮ (хорин мянган төгрөг) нэмэгдэнэ.
- III. 2024 оны 12 сарын 16-ны 18:00 цагаас хойш ямар ч тохиолдолд бүртгэлд өөрчлөлт оруулахгүй.

10. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- I. Хувь тамирчин:

Насны ангилал тус бүрд эхний гурван байр эзэлсэн тамирчдыг байр эзлүүлж урамшуулна.

1-Р БАЙР: АЛТАН МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

2-Р БАЙР: МӨНГӨН МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

3-Р БАЙР: ХҮРЭЛ МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

3-Р БАЙР: ХҮРЭЛ МЕДАЛЬ, ӨРГӨМЖЛӨЛ

II. Баг:

- Багийн дүнг медалийн чанараар дүгнэнэ. /зөвхөн насанд хүрэгчдийн ангилалд/
- Багийн дүнгээр эхний гурван байр эзэлсэн багуудыг цом, медаль, мөнгөн шагналаар урамшуулна.

III. Шилдэг дасгалжуулагч:

Эрэгтэй 1 / Эмэгтэй 1 дасгалжуулагчийг тус тус шалгаруулан шагнана.

IV. Шилдэг тамирчин:

Эрэгтэй 1 / Эмэгтэй 1 тамирчинг тус тус шалгаруулан шагнана.

V. Шилдэг шүүгч:

Тэмцээний шилдэг шүүгчээр 1 шүүгчийг шалгаруулан шагнаж урамшуулна.

11. ӨМСГӨЛ

- Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдах хэдий ч багийн нэр, логог /ивээн тэтгэгчийн/ тулааны өмсгөл болон жигдрэлийн хувцсан дээр хадахыг зөвшөөрнө.
- Тэмцээний өмсгөлийн стандарт



12. БАГИЙН АХЛАГЧДЫН УУЛЗАЛТ БОЛОН СУГАЛАА

- I. Багийн ахлагч нар 12 сарын 20-ны өдөр хуралдана.
- II. Багийн ахлагчдын уулзалтад тэмцээнд оролцох багууд төлөөллөө оролцуулах үүрэгтэй.
- III. Тэмцээний дэлгэрэнгүй хуваарийг багийн ахлагчдын уулзалтаар танилцуулна
- IV. Сугалааг тэмцээн эхлэхийн өмнө <https://www.facebook.com/MongolTaekwondo> олон нийтийн хуудаст байршуулна.

13. ЖИН ҮЗЭЛТ

- I. Оролцогчдын үндсэн жинг 12 дугаар сарын 20-ны өдөр үзнэ. /Жич: жингийн нарийвчилсан хуваарийг бүртгэл хаагдсаны дараа нийтэд зарлана/
- II. Жин тус бүрт заасан жиндээ багтаж орох хэрэгтэй ба заасан жингээс 100гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох шаардлагатай.
- III. Тэмцээнтэй өдрийн өглөө хяналтын жинг санамсаргүй түүврийн аргаар хийнэ. /эрэгтэй +87кг, эмэгтэй +73кг жингээс бусад жингүүдийн хувьд/
- IV. Хяналтын жинг тухайн жинд оролцож буй тамирчдын тоонд тохирсон тамирчдыг санамсаргүй байдлаар сонгон үзнэ. Жинг +5% нэмэгдэлтэйгээр тооцно.

Жинд хамаарах тамирчдын тоо	Хяналтын жин үзүүлэх тамирчдын тоо
32 ба түүнээс дээш тамирчин	Нийт тамирчдын 20%
17-32	6
9-16	4
4-8	2
4 хүртэлх тамирчин	0

Жингийн ангилал	Зөвшөөрөгдөх жин	Жингийн ангилал	Зөвшөөрдөгдөх жин
- 54 кг	56.7 кг жингээс хэтрэхгүй	- 46 кг	48.3 кг жингээс хэтрэхгүй
- 58 кг	60.9 кг жингээс хэтрэхгүй	- 49 кг	51.5 кг жингээс хэтрэхгүй
- 63 кг	66.2 кг жингээс хэтрэхгүй	- 53 кг	55.7 кг жингээс хэтрэхгүй
- 68 кг	71.4 кг жингээс хэтрэхгүй	- 57 кг	59.9 кг жингээс хэтрэхгүй
- 74 кг	77.7 кг жингээс хэтрэхгүй	- 62 кг	65.1 кг жингээс хэтрэхгүй
- 80 кг	84.0 кг жингээс хэтрэхгүй	- 67 кг	70.4 кг жингээс хэтрэхгүй
- 87 кг	91.4 кг жингээс хэтрэхгүй	- 73 кг	76.7 кг жингээс хэтрэхгүй

- V. Жин үзүүлэхдээ эрэгтэй тамирчид дотуур өмдтэй байх ба эмэгтэй тамирчид дотуур өмд, цээживч өмссөн байх шаардлагатай.